

# Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРГАМЖ

## АЛТАН АРГАМЖ

VOL.3

1/2000

### БНХАУ-ЫН БИЕ ДААСАН, ХАРААТ БУС, ЭНХ ТАЙВАНЧ ГАДААД БОДЛОГО

*БНХАУ-аас Монгол Улсад суугаа  
Онц бөгөөд бүрэн эрхт  
элчин сайд Хуан Яякуй*

#### 1. БНХАУ-ын гадаад бодлого – бие даасан, хараат бус, энх тайванч гадаад бодлого

БНХАУ бие даасан, хараат бус энх тайванч гадаад бодлогыг тууштай баримталдаг. Энэхүү бодлого маань Марксизм-Ленинзмийн үндсэн үзэл баримтлал, Мао Зэдүнгийн гадаад харилцааны стратегийн үзэл санааг удирдлага болгон алхам алхмаар үүсч төлөвшсөн юм. Энэхүү бодлогод дорхи гол зүйлийг агуулна, үүнд БНХАУ олон улсын асуудалд хандахдаа өөрийн байр суурь, бодлогыг бие дааж хараат бусаар боловсруулах, ямар ч гүрэн болон улс орнуудын эвсэлтэй холбоотны ба стратегийн харилцаа тогтоохгүй, жанжлах үзэл болон тулган хүлээлгэх бодлогыг эсэргүүцэх; Хятад улсын гадаад бодлогын зорилго нь дэлхий дахины энх тайвныг сахин хамгаалж, эх орны орчин үеийн бүтээн байгуулалтад олон улсын энх тайвны орчинг бүрдүүлэх; Хятад улс энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр дэлхийн бүх улс оронтой харилцааг хөгжүүлэхийн төлөө байх, хөгжиж буй орнуудтай эв нэгдэл, хамтын ажиллагааг бэхжүүлж хөрш зэргэлдээ орнуудтай сайн хөршийн найрсаг харилцаа хөгжүүлэх нь

Хятад улсын гадаад бодлогын түшиг тулгуур мөн байх; Хятад улс энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр олон улсын харилцааг болон олон улсын улс төр, эдийн засгийн шинэ дэг журмыг тогтоохын төлөө байх зэрэг болно. Манай гадаад бодлогын гол зарчим:

А. Бие даасан, хараат бус байх тухай зарчим бол БНХАУ-ын гадаад бодлогын үндсэн зарчим. Бие даасан, хараат бус байх эрх бол бүрэн эрхт улс орны үндсэн эрх. Дэн Сяопин Хятадын Коммунист Намын XII их хурлыг нээж хэлсэн үгэндээ Хятад улсын хэргийг өөрийн орны байдалтай нийцүүлэн шийдвэрлэх ёстой гэж тэмдэглэсэн юм. Бие даасан, хараат бус байхыг баримтлах нь үнэндээ Хятадын ард түмний өөрийн эрх ашиг болон эх орныхоо бодит байдалд тулгуурлан замнах зам ба бодлого сонгож Хятадын дотоод хэргийг шийдвэрлэхдээ гадаадаас ямарваа шахалт үл оролцуулан өөрийн онцлогтойгоор шийдвэрлэнэ гэсэн үг.

Б. Жанжлах үзлийг эсэргүүцэж, дэлхий дахины энх тайвныг сахин хамгаалах нь БНХАУ-ын гадаад бодлогын ерөнхий чиг хандлага мөн. БНХАУ бол социалист орон мөн болохоор Хятадын гадаад бодлого бол энх тайвныг сахин хамгаалахын төлөө байдаг. Хятад улс орчин үеийн бүтээн байгуулалт хийхдээ энх тайвны орчин хэрэгтэй. Хятад улс яриа хэлэлцээ хийж энхийн замаар олон улсын маргаантай асуудлыг шийдвэрлэхийн төлөө байдаг. Жанжлах үзэл нь дэлхийн энх тайван, аюулгүй байдалд заналхийлдэг учраас түүнийг эрс эсэргүүцэж баймааж нь дэлхий дахины энх тайвныг үр бүтээлтэй сахин хамгаалж чадна. Дэлхийн улс орнуудын ард түмэн эв нэгдэлтэй баймааж нь дэлхийн энх тайвныг сахин хамгаалах болгомжтой болно. Хойшид Хятад улс хөгжиж хүчирхэгжсэн ч гэсэн хэт их гүрэн болохыг хэзээ ч санаархахгүй, жанжлах үзэл хэзээ ч баримтлахгүй.

В. Энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим бол олон улсын харилцааг удирдан зохицуулах нийтлэг зарчим. 1953 онд Ерөнхий сайд агсан Жоу Энъйлай бүрэн эрх болон нутаг



дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтлох, дотоодын хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, эрх тэгш харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших гэсэн таван зарчмыг анх дэвшүүлж, улмаар 1954 онд Энэтхэг, Мьянмар улсад айлчлахдаа энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмыг улс орны хоорондын харилцааг зохицуулах нийтлэг зарчим болгохыг дээрх хоёр улстай хамтран санаачилсан билээ.

Энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын цөм нь улс орнуудын том жижиг, хүчирхэг буурай, баян ядуу гэхгүйгээр, нийгмийн систем, үзэл суртал, соёлын уламжлал, хөгжлийн зам өөр хооронд ялгаатай ч гэсэн, цөмөөрөө эрх тэгш, бие биеэ хүндэтгэж харилцан ашигтай байх үндсэн дээр хамтран ажиллаж эв эетэй харилцахад оршино. Таван зарчим нь тус бүрээс харилцан нөхцөлдсөн иж бүрэн организм мөн. Бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх нь бүрэн эрх зарчмыг нотлон харуулна, харилцан үл довтлох, дотоодын хэрэгт хөндлөнгөөс үл оролцох нь улс орны бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалах дутагдалгүй урьдчилсан нөхцөл юм. Эрх тэгш харилцан ашигтай байх нь улс орнууд бүрэн эрх тэгш байх, харилцан хамтран ажиллаж давуугаар нь дутуугаа нөхөх, улс төр, эдийн засаг болон соёлын харилцааг хөгжүүлэхийг шаарддаг. Одоо энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим дэлхийн олон нийтийн сэтгэлийг эзэмшиж олон улсын харилцааны нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн зарчим боллоо.

Г. БНХАУ нээлттэй байх бодлогыг тууштай баримталдаг юм. Өнөөгийн дэлхий бөмбөрцөг маань олон янзын шинж чанартай баялаг агуулгатай нээлттэй дэлхий бөмбөрцөг юм. Ямар нэгэн улс өөрийгөө хөгжүүлбэ гэвэл бусад улсуудтай харилцан хамтран ажиллаж, байх тал байхгүй талтайгаа солилцох хэрэгтэй. Өөрийн хүчинд тулгуурлахын зэрэгцээ өөрийгөө түгжмэл байдалд оруулж ганцаардуулах ёсгүй.

1978 оноос хойш Хятад улс өөрчлөн шинэчлэлт, нээлттэй байх бодлого явуулснаараа асар их амжилт хийлээ. Бид хөгжингүй болон хөгжиж буй орнуудын аль алинд нь нээлттэй байх бодлого явуулж байна. Энэхүү бодлогыг гадаад худалдаа өргөжүүлэх, гадаадаас хөрөнгө ба дэвшилт техник технологийг татан оруулах, боловсон хүчин солилцох зэрэг хэлбэрээр хэрэгжүүлдэг. Нээлттэй байх бодлогыг урагшлуулахын тулд Хятад улс давар эдийн засгийн тусгай бүс, далай эргийн нээлттэй хот, далай эргийн эдийн засгийн хөгжлийн чөлөөт бүс, шинэ өндөр техник технологийн хөгжлийн чөлөөт бүс зэргийг байгуулж, зохиистой зохион байгуулалттай, гол гол салбартай, нээлттэй байх иж бүрэн системийг бүрэлдүүлэв.

Д. БНХАУ олон улсын улс төрийн шинэ дэг журмыг тогтоохын төлөө байдаг. Өнөө үед дэлхий бөмбөрцөг маань гүн гүнзгий өөрчлөлтийн явцад оршиж байгаа бөгөөд төдийлөн энх амгалан биш байна. Жанхлах үзэл ба тулган хүлээлгэх бодлого хөгжих шинэ хандлагатай болж, зэвсэглэлээр хөөцөлдөх явдал газар авч байна. Үндэстэн ястан, шашин шүтлэг, нутаг дэвсгэрийн асуудлаас үүссэн зэвсэгт мөргөлдөөн ба бүс нутгийн дайн байлдаан тасраагүй байна. Хөгжиж буй орнууд эдийн засгаа хөгжүүлэхэд хүнд сорилт тулгарч байна. Ийм учраас Хятад улс, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын харилцааны зарчмыг удирдлага богож олон улсын шударга, зөв оновчтой улс төр, эдийн засгийн шинэ дэг журмыг тогтоохын төлөө байдаг.

## **2. 50 жилд шинэ Хятадын гадаад харилцааны ажлын тухай ерөнхий дүгнэлт**

БНХАУ хагас зууны замнал туулсан билээ. 50 жилийн хугацаанд олон улсын байдал байн байн өөрчилдөг ч гэсэн, Мао Зэдун, Дэн Сяопин, Зян Эминь нараар төлөөлүүлсэн гурван үеийн удирдах хэсгийн хүчтэй удирдлагаар Хятад улс



бие даасан, хараат бус энх тайванч гадаад бодлогыг тууштай баримталж, улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрх, нэгдмэл байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг тууштай сахин хамгаалж, эх орныхоо социализмийн бүтээн байгуулалтад олон улсын болон эргэн тойрны энх тайван, тогтвортой орчинг бүрдүүлсэн юм. Олон улсын үйл ажиллагааны талаар бид шударга ёсыг эрхэмлэн жанжлах үзэл ба тулган хүлээлгэх бодлогыг эсэргүүцэж, энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмыг баримталж, дэлхийн дийлэнх улс орнуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг тогтоосон байна. Манай улс өөрчлөн шинэчлэлт, нээлттэй байх бодлого баримталсны ачаар бүх улсын нэгдсэн чадавхи өдрөөс өдөрт нэмэгдэж, олон улсын байр суурь тасралтгүй дээшилж, олон улсын тавцан дээр улам их чухал үүрэг гүйцэтгэж байна.

Далаад наяд оны эхээр олон улсын байдал их өөрчлөгдсөн билээ. Зэвсэглэлээр хөөцөлдөх явцад ба хүйтэн дайнд ЗХУ, АНУ хоёр хэт их гүрний нэг нь аажмаар доройтож, нөгөө нь дампуурсан юм. Мөн түүнчлэн хөгжиж буй орнуудын хүчин нь өдөр ирэх тутам нэмэгдэж, баруун Европ, Япон улс бие даах ухамсар нэмэгдэж, дэлхий бөмбөрцөг маань олон туйлт байдалд шилжиж эхэллээ. Дэн Сяопин олон улсын байдлын өөрчлөлтийг харгалзан манай улсын гол анхаарлаа эдийн засгийн бүтээн байгуулалтын ажилд шилжүүлэн чиглүүлэхээр шийдвэрлэсний зэрэгцээгээр гадаад харилцааны стратегид чухал зохицуулалт, өөрчлөлт хийсэн юм. Тэрбээр "хоёр чухал өөрчлөлт"-ийг хэрэгжүүлэх зүйтэй гэжээ. Тухайлбал нэгдүгээрт, харьцангуй урт удаан хугацаанд дэлхийд их хэмжээний дайн гарахгүй байх болно, дэлхийн энх тайвныг сахин хамгаалах найдвартай гэж үзэх болсон нь дайн гарахаас зайлсхийж чадахгүй, юу юугүй зайшгүй гэсэн хуучин үзэл бодлыг маань өөрчилжээ. Хоёрдугаарт, "нэг шугамаар зааглах" гэдэг стратегийг өөрчилж, олон улсын үйл хэргийг авч үзэхдээ Хятадын ба

дэлхийн ард түмний язгуурт эрх ашгийн үүднээс, хэргийн зөв бурууг тунгааж, өөрийн байр суурь, бодлогыг бие дааж хараат бусаар боловсруулахын төлөө юм. Манай шинэ үеийн гадаад бодлогын цөм нь бие даасан, хараат бус энх тайванч гадаад бодлогыг баримталж, жанжлах үзлийг эсэргүүцэж, дэлхийн энх тайвныг сахин хамгаалж, хамтын хөгжлийг урагшлуулж, Хятадын орчин үеийн социалист бүтээн байгуулалтад олон улсын урт удаан хугацаанд тогтвортой энх тайвны орчин бүрдүүлэхэд оршдог.

### **3. Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын гадаад харилцааны талаархи амжилт**

Өөрчлөн шинэчлэлт, нээлттэй байх бодлого явуулснаас хойшхи хориод жилд Дэн Сяопингийн дэвшүүлсэн гадаад бодлогын үзэл баримтлалыг удирдлага болгон Зян Зэминээр төлөөлүүлсэн гурав дахь үеийн удирдах хэсгийн удирдлагаар Хятад улс бие даасан, хараат бус энх тайванч гадаад бодлогыг баримталж, гадаад харилцааны цоо шинэ байдлыг нээж, дэлхий нийтийн анхаарлыг татахуйц амжилтуудыг олсон юм. Үүнд:

**А. ХӨГЖИЖ БҮЙ ОРНУУДАЙ ЭВ НЭГДЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ УЛАМ БЭХЖҮҮЛЭВ.** Улс төрийн талаар бид хөгжиж буй орнуудтай харилцан дэмжилцэж, зохицуулалтыг эчимжүүлэх, хууль ёсны эрх ашгаа хамтаар сахин хамгаалдаг. Эдийн засгийн талаар бид чадлынхаа хирээр туслалцаа үзүүлэхийн хамт, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг идэвхтэй өргөжүүлж мэдэгдэхүйц амжилт олсон юм. Хятад улс, Ази, Африк, Латин Америкийн орнуудын хооронд дээд хэмжээний харилцан айлчлал тогтмогжиж, найрамдал маань гүнзгийрч, эдийн засаг, худалдааны харилцаа хэлбэрэлтгүй өргөжин, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт нягтарч байна.



Б. ЭРГЭН ТОЙРНЫ АТАЙХАН ОРЦИНГ БҮРДҮҮЛЭВ.  
Манай улс хөрш зэргэлдээ дийлэнх улс орнуудтай дипломат харилцаа тогтоосон бөгөөд удирдагч нар харилцан айлчлал хийсэн юм. Хятад улс, хөрш зэргэлдээ орнуудын хоорондын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл улам бэхжиж, Хятад улс Солонгосын хойгийн хойд, өмнөд хоёр талтай найрсаг харилцааг идэвхтэй хөгжүүлж, Өмнөд Азийн орнуудтай харилцааг үргэлжлэн хөгжүүлж, АСЕАН-тэй XXI зуунд чиглэсэн сайн хөршийн харилцан итгэлцэх түншлэлийн харилцааг тогтоож, хил залгаа дийлэнх орнуудтай хилгийн асуудлыг шийдвэрлэсэн буюу шийдвэрлэж байна. Хятад, Орос, Казак, Киргиз, Тажик таван улсын төрийн тэргүүн нарын уулзалт дөрвөн удаа хийж, Хятад улс төв Азийн улсуудтай хамтын ажиллагаа ба хөгжлийн шинэ арга замыг нээсэн байна. Эдүгээ үе бол БНХАУ байгуулагдсанаас хойш эргэн тойрны байдал хамгийн аятай үе гэж хэлж болно.

Монгол Улс бол Хятад улсын ойрын хөрш мөн бөгөөд Хятадын хойд зүгийн чухал хөрш юм. Хоёр улсын хооронд хилийн 4676 км урт шугамтай байна. Хоёр ард түмний хооронд уламжлалт зузаан найрамдалтай байдаг. 1989 оноос хойш Хятад, Монголын харилцаа хэвийн болсны дараа амжилттай хөгжиж, хоёр талын хамтын хүчин чармайлтаар бүх салбар дахь найрсаг харилцаа, хамтын ажиллагаанд маань мэдэгдэхүйц ахиц гарчээ. 1994 онд хоёр тал "БНХАУ, Монгол Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ"-г шинэчлэн байгуулж хоёр улсын харилцааг эрүүл саруул, тогтвортой хөгжүүлэхэд улс төр, эрх зүйн чухал үндэс суурийг тавив. 1998 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Хятад улсад төрийн айлчлал хийхдээ хоёр тал Хятад, Монгол XXI зуунд чиглэсэн урт удаан хугацаанд тогтвортой, эрүүл саруул, харилцан итгэлцэлтэй, сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэхээр тохиролцож, "БНХАУ, Монгол улсын хамтарсан мэдэгдэл"-ийг гаргаж, хоёр

улсын харилцааны хөгжлийн ирээдүйн чиглэлийг тодорхойлсон юм. 1999 оны 7-р сар манай улсын дарга Зян Земинь Монгол Улсад төрийн айлчлал хийснээр хоёр улсын урт удаан хугацаанд тогтвортой, эрүүл саруул, харилцан итгэлцэлтэй, сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны агуулгыг баяжуулж, харилцан ойлголцол, итгэлцэлийг улам гүнзгийрүүлж, шинэ зуун руу алхаж байгаа хоёр улсын найрамдлын гарааг эхлүүлсэн юм. 1999 оны 11-р сар Ерөнхий сайд Жү Рунжигийн урилгаар Ерөнхий сайд Р.Амаржаргал Хятад улсад ажлын айлчлал хийхдээ, хоёр тал төрийн тэргүүн нарын тохролцсон зүйлүүдийг хэрэгжүүлэх асуудлаар үр дүнтэй хэлэлцээ хийсэн юм. Одоогийн байдлаар Хятад, Монгол хоёр улсын эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагаа хэлбэрэлттэй өргөжиж, БНХАУ Монгол улсын худалдааны хамгийн том түнш бөгөөд Монголд хамгийн их хөрөнгө оруулсан орон болсон юм. Олон улсын олон асуудлаар хоёр тал адил буюу төстэй байр суурьтай байж, харилцан дэмжилцэж, нягтлан хамтран ажиллаж байна. Хятадын Засгийн газар бие даасан, хараат бус энх тайванч гадаад бодлогыг үндэслэн эргэн тойрны энх тайвны орчинг байгуулан бэхжүүлэх зорилгоор Монгол улстай сайн хөршийн найрсаг харилцааг тогтоох бодлого тууштай баримталж, Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрх ба монголын ард түмний сонгосон хөгжлийн замыг хүндэтгэж, Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэж байна. Цаашид Хятадын Засгийн газар, хятадын ард түмэн урьдын нэгэн адилгаар БНХАУ, Монгол Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээний үзэл санааны дагуу Хятад, Монголын сайн хөршийн найрсаг харилцаа, эрх тэгш харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүчин зүтгэх болно.

1999 оны 7-р сар Зян Земинь дарга Ерөнхийлөгч Багабандитай хэлэлцээ хийхдээ "Хятад, Монголын харилцаа хөгжүүлэх нь ард түмний язгуур эрх ашигт нийцэх төдийгүй,



бус нутаг болон дэлхийн энх тайван, хөгжилд ч тустай байна. Галчхүүл хоёр тал БНХАУ, Монгол Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээний Үндсэн зарчмыг чанд сахиж, хоёр улсын харилцааны гол чиг хандлагыг тууштай баримталбал хоёр ард түмэндээ улам их ашгийг авчирч, хоёр улсын хамтын цэцэглэн хөгжилд түлхэц өгч Хятад, Монгол хоёр улс лав сайн найз, сайн хөрш болох нь дамжиггүй" хэмээн тэмдэглэв.

**В. ТОМ ГҮРЭНТЭЙ ХАРИЛЦААНЫ ХАРЬЦАНГУЙ ТОГТВОРТОЙ ЧИГ БАРИМЖААГ БИЙ БОЛГОВ.** Хятад, АНУ хоёр улс эрүүл саруул, тогтвортой харилцааг байлгах нь хоёр улсын язгуур эрх ашигт нийцэх төдийгүй, Ази-Номхон далайн болон дэлхийн энх тайван, тогтвортой байдалд ч ашигтай байна. БНХАУ, АНУ-тай дипломат харилцаа тогтоосноос хойшхи хориод жилийн хугацаанд хоёр улсын харилцаанд зөрчил бэрхшээл байн байн гарсан боловч гол хандлага нь урагшаа хөгжиж ирсэн юм. Хоёр улсын төрийн тэргүүн нарын харилцан айлчлал хийснээр ХХI зуунд чиглэсэн бүтээлч стратегийн түншлэлийн харилцаа тогтооход хамтран хүчин зүтгэхээр шийдвэрлэж, хоёр зууны зааг дээрх Хятад, Америкийн харилцааны бүдүүвчийг төлөвшүүлж хөгжлийнхээ чиглэлийг тодорхойлсон байна.

**БНХАУ, ОХУ-тай ХХI зуунд чиглэсэн стратегийн хамтын ажиллагааны түншлэлийн харилцааг тогтоосон юм.** Энэ нь холбоотны бус, үл сөргөлдөх, гуравдагч улс орны эсрэг чиглэхгүй шинэ маягийн улс хоорондын харилцаа юм. Хятад, Оросын удирдагчид тогтмол уулзах тогтолцоо байгуулж түүхийн үлдсэн хилгийн ихэнх асуудлыг шийдвэрлэсэн юм. Хоёр тал хоёр зууны зааг дээр хамтын ажиллагааны шинэ салбарыг цуцалтгүй нээж, Хятад, Оросын стратегийн хамтын ажиллагааны түншлэлийн харилцааг улам их баяжуулж төгөлдөржүүлэх ёстойг илэрхийлсэн юм.

Хятад, Японы харилцаа хэвийн болсны дараа ерөнхийдөө хөгжих хандлага хадгалсан юм. 1998 онд Зян

Зэминь дарга Японд айлчлал хийхдээ хоёр тал түүхээс сургаж авч ирээдүйгээ харах үзэл санааны дагуу, энх тайван, хөгжилд чиглэсэн найрсаг хамтран ажиллах түншлэлийн харилцааг тогтоохоор шийдвэрлэж ХХI зуунд Хятад, Японы харилцааны чухал чиглэлийг тодорхойлов.

Хятад, Европын харилцаанд шинэ шинэ ахиц гарч байна. Хятад, Европын холбооны хооронд удирдагчдын тогтмол уулзах механизм бий болгож, ХХI зуунд чиглэсэн урт удаан хугацаанд тогтвортой, бүтээлч түншлэлийн харилцаа тогтоосон юм. Хятад, Европын холбооны гишүүн орнуудын хоорондын дээд хэмжээнд харилцан хийсэн айлчлал тогтмолжиж, худалдаа, эдийн засгийн харилцаа хэлбэрэлтгүй өргөжиж, бүх салбар дахь хамтын ажиллагаа үр бүтээлтэй, сайхан ирээдүйтэй байна.

**Г. ЭХ ОРНОО НЭГТГЭХ ҮЙЛСИЙГ ТУУШТАЙ УРАГШЛУУЛЖ БАЙНА.** Манай Засгийн газар Хонконг болон Макао д бүрэн эрхээ амжилттай сэргээгээд "нэг улс хоёр систем" гэсэн агуу их үзэл баримтлал нь Хонконг, Макао д биелэгдлээ. Сүүлийн хоёр жилд Азийн санхүүгийн хямралд хүнд нэрвэгдсэн ч гэсэн, Хонконгийн эдийн засаг, нийгмийн байдал тогтвортой хэвээр байна. Хонконгийн эх орон нэгтнүүд эх орныхоо болон Хонконгийн ирээдүйд итгэл төгс байна.

Тайванийн асуудлыг шийдвэрлэж, Хятадын бүрэн нэгдэхийг биелүүлэх нь Хятадын үндэстнүүдийн ард түмний язгуур эрх ашигт нийцдэг бөгөөд үүний төлөө Хятадын Засгийн газар тавин жилийн турш цуцалтгүй хүчин зүтгэж, "нэг улс хоёр систем"-ийн хэрэгжүүлэх замаар эх орноо энх тайвнаар нэгтгэх зорилго тавьж ажиллаж байна. Гэвч ерээд оноос хойш Тайванийн эрх баригч Ли Дэхүй "нэг Хятадын тухай зарчим"-аас урваж "улсын хоорондын онцгой харилцаа, буюу "хоёр улсын онол" гэгчийг ухуулж, Тайванийн хоолойн хоёр талыг эх орноо энхийн аргаар нэгтгэх үндсийг ноцтойгоор сүйтгэв. Гэхдээ Ли Дэхүйн "хоёр улсын онол"



гэгчид ард түмэн дургүйцэж байна. Одоо дэлхийн зуугаад орон нэг Хятадын тухай зарчмыг дэмжихийг дахин нотолж байна.

Хятадын Засгийн газар "хоёр хятад" буюу "нэг хятад нэг тайвань" гэгчийг эрс эсэргүүцэж, Ли Дэнхүйн "хоёр улсын" онолыг эрс эсэргүүцэж байна. Сүүлийн үед манай Засгийн газар "нэг Хятадын тухай зарчим ба Тайваний асуудал" гэдэг цагаан ном гаргаж, нэг Хятадын тухай зарчим, байр суурийг тууштай баримтлахыг тодорхойлов. Хятадын Засгийн газар Хонконг, Макао-д бүрэн эрхээ сэргээсний дараа Хятадын бүх үндэстнүүдийн ард түмэн Тайваний асуудлыг аль эрт шийдвэрлэхийг хүсч байна. Тайваний асуудлыг хугацаагүй хойшлуулахыг бид зөвшөөрөхгүй юм.

**Д. ХЯТАД УЛС ОЛОН УЛСЫН ТАВЦАН ДЭЭР ИДЭВХТЭЙ ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ.** БНХАУ бол дэлхийн хамгийн том хөгжиж буй орон, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн орон мөн бөгөөд дэлхийн энх тайвныг сахин хамгаалах, хамтын хөгжлийг урагшлуулах гол хүчин юм. Энх тайван байх уу эсвэл дайн гарах уу гэсэн чухал асуудлаар, жишээлбэл Иракийн, Косовогийн хямралын талаар Хятад улс шударга ёсыг тууштай дээдлэн, олон улсын маргаантай асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхийн төлөө зүтгэж, хүч хэрэглэх буюу зэвсэглэлээр сүрдүүлэх явдлыг эсэргүүцэж, ямар нэг нэрийдлээр бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг эсэргүүцэж, түгшүүртэй байдлыг намжааж хямралыг улс төрийн замаар шийдвэрлэхэд онцгой бүтээлч үүрэг гүйцэтгэсэн юм. Азийн санхүүгийн хямралд Хятад улс хүнд дарамтанд нэрвэгдсэн ч гэсэн маш хариуцлагатай хандлагаар хандаж Хятадын юаний хаш бууруулахгүй бодлого баримталж, бүс нутаг болон дэлхийн эдийн засгийн тогтвортой байдалд чухал хувь нэмрээ оруулсан байна.

Зэвсэгт хяналт тавих салбарт БНХАУ цөмийн зэвсгийг бүрэн хориглож бүрмөсөн устгахын төлөө байдаг. Жараад оны үеэр Хятад улс цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй,

цөмийн зэвсэггүй улс орон ба бүс нутагт цөмийн зэвсэг хэрэглэхгүй буюу цөмийн зэвсэглэлээр сүрдүүлэхгүй дангаараа амласан билээ. Хятад улс олон улсын зэвсэг хураах үйл явцад бүх талаар оролцож, түлхэц өгсөн юм. 1985 онд өөрийн цэргийн тоог нэг саяар хорогдуулаад 1997 онд таван зуун мянгаар хорогдуулахаар дахин шийдвэрлэв.

Хүний эрхийн салбарт БНХАУ олон улсын хүний эрхийн тухай 17 конвенцид нэгдсэн байна. Хятад улс ард түмнийхээ хүний эрхийн байдлыг сайжруулахад цуцалтгүй хүчин чармайлт гаргаж, дэлхийн нийтийн анхаарлыг татахуйц амжилт олсон билээ.

Хятад улс олон талын эдийн засаг, нийгмийн салбар дахь төрөл бүрийн үйл ажиллагаанд өргөнөөр оролцож, хүрээлэн байгаа орчин, хүнсний, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, хар тамхийн эсрэг, дүрвэгсэд, эмэгтэйчүүдийн зэрэг глобалчлалын шинжтэй асуудлуудыг шийдвэрлэх талаар нааштай үүрэг гүйцэтгэж, АПЕК болон Ази-Европийн бага хурлын явцыг эрүүл саруулаар урагшлуулахад чухал хувь нэмрээ оруулсан юм.

**Е. БНХАУ, ХӨГЖИЖ БҮЙ ОРНУУДЫН ХООРОНДЫН НАЙРСАГ ХАМТЫН АЖИЛЛАГАА ШИНЭЭР ХӨГЖИЖ БАЙНА.** Сүүлийн жилүүдэд манай улс хөгжиж буй орнуудтай улс төр, эдийн засаг зэрэг салбар дахь найрсаг хамтын ажиллагаа нь шинэ байдалд шинээр хөгжиж байна. Манай улсын удирдагчид, хөгжиж буй орнуудын удирдагчид харилцан хийсэн айлчлалаар, харилцан ойлголцол итгэлцлийг гүнзгийрүүлж, олон улсын томоохон асуудлаар зөвлөлдөж харилцан дэмжих явдлыг эрчимжүүлж, эдийн засаг, худалдааны салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг нягтруулав. Саяхан Зян Земинь дарга Африкийн орнуудын удирдагч нарт илгээлт явуулж "БНХАУ, Африкийн хамтын ажиллагааны форум — 2000 оны сайд нарын Бээжингийн уулзалт"-ыг зохион байгуулахыг санаачилсан юм. Үүнийг Африкийн орнуудын Засгийн газар талархан



нааштай хариу өгчээ.

#### 4. БНХАУ-ын гадаад харилцааны ирээдүйн төлөв

Өнөө үед Хятад улсын гадаад харилцаанд голдуу хоёр сорилт тулгарч байна. Нэг нь олон улсын байдалд тогтворгүй, тодорхойгүй хүчин зүйл нэмэгдэж, жанжлах үзэл, тулган хүлээлгэх бодлого шинээр хөгжиж, цэргийн эвслийг бэхжүүлэх болон "бүрэн эрхээс хүний эрхийг дээр тавих", "хүмүүнлэг оролцоо" гэгч халхавчаар бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох аюултай хандлага газар авч, НҮБ-ын дүрмийн үндсэн зорилго зарчим болон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын харилцааны дэг журам нь ноцтой сорилт тулгарч байна. Нөгөө нь эдийн засгийн глобалчлалын хандлага хурдасгаж, ядуу, баяны ялгаа ихсэж, Өмнө, Хойдын зөрчил өдрөөс өдөрт хурцдаж байна. Сөрөг үр дагавараас зайлсхийж, өөрсдийн эдийн засгийн аюулгүй байдлыг сахин хамгаалах нь улс орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд хойшлуулашгүй асуудал болж байна.

Манай улсын өмнө тохиолдож байгаа олон улсын харилцааны ерөнхий байдал болон эргэн тойрны орчны хувьд боломж нь сорилтоос их, найдвар нь бэрхшээлээс их байна. Хүйтэн дайны эцэслэснээс хойш арваад жилд, олон улсын байдал ерөнхийдөө намжиж, дэлхий нийтийн хэмжээний дайн гарахгүй болно. Дэлхийн улс төрийн тогтолцоо олон туйлт байдалд шилжих явц бартаатай, ээдрээтэй ч гэсэн энэхүү хөгжлийн хандлага эргэлтгүй болсон юм. Энх тайван ба хөгжил нь хоёр зууны зааг дээрх цаг үеийн гол сэдэв бөгөөд эдийн засгийг хөгжүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлж, улс орныхоо нэгдсэн чадавхийг дээшлүүлэх нь улс орнуудын гол зорилго чиглэл хэвээр байна. БНХАУ бие даасан, хараат бус энх тайванч гадаад бодлогыг тууштай баримталж, дэлхийн улс орнуудын ард

Түмэнтэй хамт, олон улсын улс төр, эдийн засгийн шударга, зөв оновчтой шинэ дэг журмыг тогтоохын төлөө улам их хүчин чармайлт гаргах болно.